



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 18 өдөр

Дугаар A/35

Рашаант сум

**Эзэмшил газрын талбайн хэмжээнд
өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.5 дахь заалт, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7 дахь заалт, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 15-ний өдрийн "Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" A/133 дугаар тушаалын 8.9.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын иргэн Дамдинтовуу овогтой Энхтуяагийн хүсэлтийн дагуу Талын-Ус багийн Баянхөндийн шонт гэдэг газарт байршилтай 6706002999 нэгж талбарын дугаартай үр тарианы зориулалттай газрыг 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн A/02 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 8 дугаар мөрийн 100,000 м² гэж гаргасан шийдвэрийг цахимд 117,392 м² оруулсан байгаа тул засаж 100,000 м² болгон үлдсэн 11 жилийн хугацаатайгаар өөрчлөн эзэмшүүлсүгэй.

2.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн A/02 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 8 дугаар мөрийг хүчингүйд тооцсугай.

3.Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэдтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (Б.Ариунжаргал)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн биелэлтэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Т.Отгонцэцэг)-д, байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (М.Билэгдэмбэрэл) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ

